


Forward

The Mongolia went through a number of transformations- first from a pastoral, feudal society to a socialist-industrial-agricultural one and then recently to democratic society having market economy. These socio-economic changes have made the study of Mongolians economic and demographic situations somewhat complex. The difficulties in conducting socio-economic research are further compounded by serious limitations in the availability of relevant data, particularly the lack of published data.

Though Mongolia has the advantages of relatively well developed the data collection system and the Government of Mongolia have shown keen interest in the importance of population aspects in the development process of the country, the efforts made till now in area of analysis and utilisation of population data for policy formulation have not been adequate.


The population research got a strong push in Mongolia with the setting up of Population Teaching and Research Center (PTRC) at the Mongolian National University in 1992 with financial support from United Nations Population Fund (UNFPA). It has conducted largescale demographic surveys and research in the areas of priority concerns. Unfortunately, till now there is no research journal in Mongolia where the researchers can publish their research work. The PTRC has accepted the challenge of making available such journal. In this effort, the teachers and staff of the PTRC have taken painstaking efforts under the leadership of Dr. Pandey, UN Technical Adviser attached to the PTRC. I would like to thank him and his team members for the hard work put in by them in bringing out this journal out of their own initiatives.

I hope this journal will be very useful to researchers, policy makers, parliamentarians, teachers in Mongolia. To the international readers, the articles included in the journal will provide insights into demographic scenario of the country.



(Prof. D. Dorj)
Rector

Mongolian National University




Өмнөх үг

Монгол улс нь феодалын хоцрогдмол нийгмээс хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болох түүхэн хөгжлийг туулсан бөгөөд 1990 оноос зах зээлийн эдийн засагтай ардчилсан нийгэмд шилжих үйл явц үргэлжилж байна. Өнөөдөр нийгэм эдийн засгийн өргөн хүрээг хамарсан өөрчлөлтөөс үүдэн Монгол орны эдийн засаг, хүн ам зүйн төлөв байдлыг судлах зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Монгол орны хөгжлийн үйл явцад хүн амын асуудал чухал гэдэгт засгийн газар байнга анхаарлаа хандуулсаар ирсэн билээ. Монголд мэдээллийн систем харьцангуй сайн хөгжсөн хэдий ч хүн ам зүйн мэдээллийг ашиглан төрийн аливаа бодлого боловсруулах түвшинд хүртэл шинжилгээ, судалгаа хийх явдал хангалтгүй байна.

НҮБ-ын Хүн Амын Сангийн тусламжтайгаар 1992 онд МУИС-ийн дэргэд байгуулагдсан Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төв нь хүн ам зүйн сургалт явуулахаас гадна судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлд онцгой анхаарал тавин ажиллаж байна. Харамсалтай нь өнөөг хүртэл Монголын хүн ам зүй судлаачдад өөрсдийн бүтээлээ нийтлүүлэх судалгааны тогтмол сэтгүүл хараахан байхгүй байна. ХАЗССТ-өөс энэ төрлийн сэтгүүл бий болгох анхны оролдлого хийлээ. Өөрсдийн санаачилгаар шаргуу ажиллаж буй ХАЗССТ-ийн багш нар болон тус төвийн НҮБ-н зөвлөх доктор Панди нарт өөрийнхөө өмнөөс талархаж байгаагаа илэрхийлье.

Энэ сэтгүүл нь судлаачид, бодлого боловсруулагчид болон бусад сонирхсон хүмүүсийн таашаалд нийцнэ гэдэгт найдаж байна. Мөн түүнчлэн энэ сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллүүд нь гадаадын уншигчдад Монголын хүн амын талаарх мэдээлэл өгөхөд тус дөхөм болох болов уу.



(Профессор Д. Дорж)
Ректор
Монгол Улсын Их Сургууль

From The Chief Editor's Desk

Soon after my joining the PTRC as the Technical Adviser in November, 1995, I was given the responsibility to finalise the report of the first Mongolian Demographic Survey. In this connection I wanted to refer some research work but I was informed that there is no research journal in Mongolia which gives details of the research on various aspects of population and related issues. The idea of bringing out this journal took birth at that time itself. I discussed the feasibility of such proposal with my colleagues at the PTRC and as a team we decided to take it as a challenge. I'm happy to keep a copy of this journal in your hand which has involved a very hard work on the part of all of my colleagues for the last 4-5 months.

As the first step in this endeavour, we invited research articles from national and international experts in Mongolia working in the field of population and related subjects. Keeping in view the language limitations, the experts were given the option to write either in Mongolian or in English. Because of this approach, this journal has Mongolian and English sections. Being the first venture of its sort, perhaps, the experts were not sure about its success as we could not receive many articles from outside in spite of continuous follow up by us. Because of this limitation out of the 13 articles included in this journal, 7 are contributed by experts from PTRC. I'm sure for the next issue other experts will generously contribute articles.

All the work relating to designing of the cover page and the overall layout of the journal have been handled by us at the PTRC itself without any outside support. Therefore, there is still ample scope for improving the gate-up of the journal. We will try to do it in the next issue. I'm thankful to my editor colleagues for editing various articles. We have utilised some of the funds available in the UNFPA Project MON/92/P04 for printing the journal. We are grateful to the UNFPA for this financial support.

Being the first issue of the journal, I'm aware of its various limitations. We shall be grateful for comments and suggestions for improvement in the coverage and quality of the journal from all our readers.

Dr. R. N. Pandey
Chief Editor

Редакторын үг

1995 оны 11-р сараас Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төвд НҮБ-ын Хүн Амын Сангийн зөвлөхөөр ажиллаж эхэлсний дараахан 1994 оны Хүн Ам Зүйн Судалгааны эцсийн илтгэлийг бэлтгэх үүрэг ногдсон юм. Үүнээс үүдэн хүн ам болон түүнтэй холбогдох олон төрлийн судалгаа шинжилгээний бүтээлүүдийг хэвлэн нийтэлж олны хүртээл болгох тогтмол хэвлэл үгүйлэгдэж буйг мэдсэн юм. Энэ талаар ХАЗССТ-ийн хамт олонтой ярилцаж тохиролцсоны үндсэн дээр ийм сэтгүүл гаргах анхны оролдлого хийж байна. Манай хамт олны сүүлийн 4-5 сарын шаргуу хөдөлмөрийн үр дүнд бий болсон сэтгүүлийн анхны дугаарыг уншигч олны гар дээр хүргэж байгаадаа сэтгэл дүүрэн байна.

Юуны өмнө Монголд хүн ам түүнтэй уялдаа бүхий салбарт ажиллаж буй гадаад дотоодын эрдэмтэн судлаачид нараас сэтгүүлд зориулсан бүтээлээ ирүүлэхийг хүссэн юм. Хэлний боломжийг харгалзан зохиогчид нь Англи эсвэл Монгол хэл дээр бүтээлээ бичиж ирүүлэхийг санал болгосон. Энэ нь бидний анхны оролдлого байсан бөгөөд төдийлөн олон өгүүлийг бусад судлаачдаас хүлээн авч чадаагүй учраас анхны дугаарт ихэвчлэн ХАЗССТ-ийн багш мэргэжилтнүүдийн бүтээл багтсан юм. Гэхдээ дараагийн дугаарт бусад эрдэмтэд, судлаачид өгөөмөр сэтгэлийн үүднээс оролцоно гэж найдаж байна.

Тус сэтгүүлийн эх, зураг чимэглэл болон бусад бүх ажлыг ХАЗССТ-ийн хамт олон биеэ даан гардан хийсэн. Цаашид тус сэтгүүлийн цар хүрээг өргөтгөн, чанарын шинэ түвшинд гаргах шаардлагатай байна. Энэ зорилтоо дараа дараагийн дугаарт хэрэгжүүлэхийг чармайх болно. Өгүүдэлүүдийг редакторласан редакцийн гишүүдэд талархалаа илэрхийлье. Тус сэтгүүлийг хэвлэхэд санхүүгийн тусламж үзүүлсэн НҮБ-ын Хүн Амын Санд гүн талархлаа илэрхийлье.

Тус сэтгүүлийн анхны дугаарыг гаргахад олон зүйлийн бэрхшээл байсан нь тодорхой юм. Уншигч олноос тус сэтгүүлийн үзэмж, чанарыг сайжруулахтай холбогдсон санал сэтгэгдлээ ирүүлбэл гүнээ талархах болно.

Доктор Р. Н. Панди
ерөнхий редактор